



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Балжиннямын БАЯРСАЙХАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-22-41, Факс: 32-70-16
E-mail: bbayarsaikhan@parliament.mn
http://www.parliament.mn

2024.01.16 № УЦЯ-03/461

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Цахим орчинд хүүхдийг хамгаалах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.БАЯРСАЙХАН
Ц.САНДАГ-ОЧИР
Б.ЖАРГАЛМАА
Ц.МӨНХЦЭЦЭГ

• 2024000005



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Балжиннямьын БАЯРСАЙХАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-22-41, Факс: 32-70-16
E-mail: bbayarsaikhan@parliament.mn
<http://www.parliament.mn>

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

2023 10 17 № УИХ-03/8074

танай _____ -ны № _____ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх Г
ТОВ ТОГТООЛГОХ ТУХАЙ

Миний бие Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.


Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, зардлын тооцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлсэн үнэлгээний тайлан, саналын товъёогийг тус тус хавсаргав.

Хавсралт **137** хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.БАЯРСАЙХАН

2023000227

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлд:

“VII.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы санаачлан боловсруулсан Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы санаачлан боловсруулсан Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцээд, дараах саналыг хууль санаачлагчид хүргүүлэхээр тогтов. Үүнд:

1.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар хүүхдийн талаарх мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, түгээхтэй холбогдсон харилцааг мөн хуулиар зохицуулахаар тусгасан байна. Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг тул хуулийн төслийн дээрх зохицуулалт нь хууль хоорондын давхардал, зөрчил үүсгэж болзошгүйг анхаарах.

2.Хуулийн төсөлд “цахим сүлжээний шүүлтийн программ” гэдгийг контентыг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт зориулан шүүн ангилах, түгээх цогц үйл ажиллагаа гэж тодорхойлсон байх бөгөөд үүнийг хэрхэн, ямар техник технологийн тусламжтайгаар контентыг шүүн ангилах, түгээх нь тодорхойгүй байгааг анхаарах.

3.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад “цахим сүлжээний үйлчилгээ эрхлэгч” гэдэгт үүрэн телефоны оператор, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим хуудас эрхлэгч, мөн эдгээр үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр эрхлэх”-ийг хамруулж, төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Цахим сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь цахим сүлжээн дэх контентыг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт зориулан шүүн ангилна” гэж заажээ.

Цахим сүлжээний үйлчилгээ эрхлэгч гэдэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээ, мэдээллийн вэбсайт, Facebook, Instagram зэрэг олон нийтийн сүлжээ мөн хамаарч байгаа эсэх, хэрэв хамаарч байгаа бол тэдгээр нь хэрхэн контентыг шүүн ангилж, контентын талаар гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэх нь тодорхойгүй байгааг анхаарах.

4.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 11.1.7 дахь заалт бүрэн бус байгааг анхаарах.

5.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн гомдол, мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл журмын дагуу холбогдох эрх бүхий этгээд шалган шийдвэрлэхээр заасан нь агуулгын хувьд төслийн 13.5 дахь хэсэгтэй давхардаж байгаа тул 13.5 дахь хэсгийг хасах.

